

БЭЛГИЙН ЦӨӨНХИЙН ХҮНИЙ ЭРХ

Монгол Улс нь аливаа үндэслэлээр ялгаварлан гадуурхахыг хориглосон олон тооны олон улсын гэрээнд нэгдэж орсноос гадна лесбиян, гей, бисексуал, трансжендэр (ЛГБТ) хүмүүсийг тэгш хамгаалах шаардлагатай талаар Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэг болон

олон улсын гэрээний хороод (Эрүүдэн шүүхийн эсрэг хорооноос 2010 онд, Хүний эрхийн хорооноос 2011 онд)-оос зөвлөмж авсан хэдий ч эдгээр зөвлөмж биелээгүйгээс үүдэн ЛГБТ хүмүүс өдөр тутам ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэлд өртөх хөрс суурь болсоор байна.

ЛГБТ хүмүүсийн хувьд доорх эрхүүд түгээмэл зөрчигдөж байна:

- Амьд явах эрх
- Бие махбодийн хувьд халдашгүй дархан, аюулгүй байх эрх
- Тэгш хамгаалагдах эрх
- Ялгаварлан гадуурхалтад өртөхгүй байх эрх
- Үзэл бодолтой байх, түүнийгээ илэрхийлэх эрх
- Боловсрол эзэмших эрх
- Шударга ёс хүртэх эрх
- Соёлын амьдралд оролцох эрх
- Олон нийтийн орон зайд байх эрх
- Шаардлага хангахуйц амьжиргааны түвшинтэй байх эрх
- Сэтгэцийн болон биеийн эрүүл мэндийн хүрч болох дээд жишгийн үйлчилгээг хүртэх эрх
- Гэр бүл болох эрх
- Өмчлөх эрх

ТУЛГАМДАЖ БҮЙ АСУУДАЛ

ЛГБТ хүмүүсийг үл тэвчих, ялгаварлан гадуурхах, хүчирхийлэх хэлбэрүүд Монголд олон хэлбэрээр илэрсээр байдаг ба энэ хэлбэрүүд нь харилцан уялдаатай учир бие биеэ тэтгэж, ялгаварлан гадуурхалт оршсоор байх бат үндэс болдог. ЛГБТ хүмүүсийн ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрх хамгаалагдаагүйгээс нэг төрлийн ялгаварлан гадуурхалт бусад ялгаварлалд хүргэснээр амьд явах, бие махбодийн хувьд халдашгүй дархан, аюулгүй байх, тэгш хамгаалагдах, шударга шүүхээр шүүлгэх болон зөрчигдсөн эрхээ сэргээлгэх буюу шударга ёс хүртэх эрх, үзэл бодолтой байх, түүнийгээ илэрхийлэх (энэ нь ялангуяа хүйсийн баримжаа, илэрхийллийн хувьд хамаатай) зэрэг үндсэн эрх, эрх чөлөөгөө ЛГБТ хүмүүс эдлэх боломжгүй байдалд хүргэж байна.

КЭЙС, БАРИМТ, ТАЙЛБАР

Нээлттэй амьдардаг гей А.О. нь 2014 оны 3-р сарын эхээр Баянгол дүүргийн 1-р хорооны нутаг дэвсгэрт нас барсан байдалтайгаар олдсон. Түүнээс өмнө тэрээр 2013 оны 12-р сард хүчиндүүлсэн тухай хэрэг бүртгүүлж байсан ч түүнийгээ эргэж татсан ба 2014 оны 1-р сарын сүүлээр хоёр дах удаа хүчиндүүлсэн тухайгаа цагдаад мэдэгдэж, хэрэг бүртгүүлж байсан. Хэрэг үүсгэх явцад түүнийг Сүхбаатар дүүргийн прокурорын ажилтан хэл амаар доромжилсон. Түүний амь нас ямар байдлаар, ямар шалтгаанаар хохирсон тухай мэдээллийг цагдаагийн байгууллага ЛГБТ Төвд гаргаагүй ба энэхүү хэрэг бусдын нөлөөтэй үйлдэгдсэн байх боломж өндөр байсан ч “амиа егүүтгэсэн” хэмээн хаасан.

ЛГБТ хүмүүсийн эсрэг хууль сахиулах байгууллагуудын ялгаварлан гадуурхалт оршсоор байна. Үүнд: ЛГБТ гэдэг нь мэдэгдсэн хүмүүсийг тагнах, хувийн нууц, орон зайд нь халдах, утсыг нь чагнах, үндэслэлгүй саатуулах, саатуулагдсан тохиолдолд хууль сахиулах байгууллагуудын бие бүрэлдэхүүн эсвэл хамт саатуулагдагсад ЛГБТ хүмүүсийг бие махбодь, бэлгийн хувьд хүчирхийлэх, хүчирхийлэхээр заналхийлэх, бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийллийнхээ үндсэн дээр гэмт халдлагад өртсөн тохиолдолд хэргийг бүртгэхгүй байх, үзэн ядалтаас үүдэлтэй гэмт хэргийг шүүн таслахдаа гэмт хэрэгтэнд ял оноолгүй шударга ёсыг тогтоохгүй үлдээх гэх мэтээр илэрч байна.

Транс эмэгтэйчүүдийг үндэслэлгүй биеэ үнэлэгч хэмээн тооцох, нийтийн орон зайд (гудамжинд) тодорхой цагаас хойш байх эрхийг нь үгүйсгэснээр өөрийн хүйсийг хувцаслалт, зан үйлээр илэрхийлэх хүйсийн баримжаа, илэрхийллийг шууд бус байдлаар гэмт хэрэгт тооцож буй асуудал ноцтой байна.

ЛГБТ хүмүүс хосоороо амьдарч буйг мэдсэн тохиолдолд тэдэнд орон байр түрээслэхгүй байх, түрээсийн орон байраас хүчээр гаргах асуудал ноцтой байна. ЛГБТ хүмүүсийн эсрэг гэр бүлийн хүчирхийллийн хэмжээ ноцтой байсаар байгаа нь ЛГБТ хүмүүс аюулгүй, халдашгүй байх, шаардлага хангахуйц орон байр, амьжиргааны түвшинтэй байх, ижил хүйсийн хос, эсвэл хосын нэг нь транс хүн байх тохиолдолд тэдний харилцааг үгүйсгэснээр эсвэл хүүхдийг нь үгүйсгэснээр гэр бүл зохиох, өмчтэй байх эрхээ эдлэж чадахгүй байдалд оруулж байна.

Эрүүл мэндийн салбарын гетеронорматив хүрээ, салбарын ЛГБТ хүмүүсийн эрүүл мэндийн талаарх мэдээлэл, чадавч, хандлага байхгүйгээс үүдэн ЛГБТ олон нийтийг бүрдүүлэгч дэд олон нийт бүрийн эрүүл мэндийн тодорхой хэрэгцээ хангагдахгүй, сэтгэцийн эрүүл мэндийн асуудал, хүйсийн шилжилттэй холбоотой даавар орлуулах эмчилгээ болон хагалгаанууд эрүүл мэндийн даатгалд ороогүйгээс үүдэн ЛГБТ хүмүүсийн эрүүл мэндээ бүрэн хамгаалуулах үндэс бүрдээгүй байна.

Гетеронорматив хэм хэмжээ боловсролын тогтолцоонд хүчтэй байсаар байгаа нь ялгаварлан гадуурхалтыг өөгшүүлж, сурч боловсрох, соёлын болон нийтийн орон зайд байх эрхийг ЛГБТ хүмүүсийн хувьд эдлэх боломжгүй нөхцөлд хүргэж байна. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын 2011 оны 12-р сарын 10-ны өдөр тутмын хоёр сонинд гаргасан бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийллээр ялгаварлахгүй байх уриалга, 2012 онд цацсан нэг шторк, телевизийн нэвтрүүлгийг эс дурьдвал Монгол Улсын Засгийн газар бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийллээр үл ялгаварлах асуудлаар олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагаа огт хийгээгүй.

2011 оны 5-р сарын 11-нд нээлттэй амьдардаг транс эрэгтэй Н. О.-руу найз охиных нь эх Б. Ц. хутга барин дайрч, биед нь халдсан. Халдлагын үеэр Б. Ц. нь Н. О.-г “Ертөнцийн хог шаар, охиныг маань уруу татсан” хэмээн үг хэлээр давхар доромжилсон. Тухайн халдлагыг тухайн үед Баянзүрх дүүргийн цагдаад бүртгүүлсэн боловч Н. О. найз охиныхоо ятгалгаар гомдлоо татсан. Хэдий тийм ч Н. О.-ийн найз охиных нь гэр орныхон түүнийг 2014 оны 9-р сар хүртэл өдөр бүр утсаар доромжлон дарамталсаар байсан.

2012 оны 2-р сарын 25-ны өдөр нээлттэй амьдардаг транс эрэгтэй Н. А.-г хүйсийн шилжилтэд орохоос нь өмнө мэддэг, эгчийнх нь найз залуу байсан Э. Г. зодож, нүдний ухархайг нь цөмлөж, тархийг нь доргиож, хүнд гэмтээсэн. Чингэлтэй дүүргийн Эрүүгийн шүүх Э. Г.-ыг гэмт хэрэгт буруутайд тооцсон ч ял оноогоогүй нь цагдаа болон прокурорын байгууллагын алдаатай шууд холбоотой. Тухайн халдлагаас Н. А.-д учирсан гэмтэл нь хүнд зэргийн байсныг нотлосон эмнэлгийн тодорхойлолтыг Чингэлтэй дүүргийн цагдаа, прокурорын байгууллага үрэгдүүлж, шүүн таслах үйл ажиллагааг санаатайгаар хойшлуулж, хэрэг гарснаас хойш 6 сарын дараа явуулсан, мөн ялтан анх удаа гэмт хэрэгт холбогдсон хэмээх шалтгаар түүний гэмт хэргийг хөнгөвчилж, шударга ёсыг тогтоогоогүй.

Нээлттэй амьдардаг транс эмэгтэй Э. С. ба Э. М. нарыг 2014 оны 3-р сарын 28-нд Чингэлтэй дүүргийн эргүүлийн цагдаа биеэ үнэлсэн хэргээр саатуулсан. Өглөө нь тэд мэдүүлэг өгөх үеэр хотын цагдаагийн ажилтан TV8 телевизийн мэдээний багийг оруулж ирэн “биеэ үнэлэгчид” хэмээн бичлэг хийлгэсэн. Хоёр эмэгтэй суллагдсаны дараа TV8 телевиз тэднийг дахин дагаж, бичлэг хийн 4-р сарын дундуур олон нийтэд цацсанаар тухайн транс эмэгтэйчүүдийн амь нас, аюулгүй байдал нь эрсдэлд орсон. Цагдаагийн ажилтны хариуцлагагүй үйлдэл энэхүү ноцтой эрсдэлд хүргэсэн.

Нээлттэй амьдардаг гей, ЛГБТ клуб нэртэй үйл ажиллагаа явуулдаг ганц клуб болох “Ханзо”-гийн эзэн А. З.-г 2014 оны 6-р сарын 1-ний өдрийн 03 цагт хаах цагаас хойш клубд байсаар байсан 5 хүн түүнийг зодож, хамрыг нь хугалж, тархийг нь доргиосон. Хэрэг гарсны дараа Чингэлтэй дүүргийн цагдаад бүртгүүлэхээр очиход хохирогчийг “Согтуу байна” хэмээн хэргийг нь бүртгэхээс татгалзсан.

У., С. хоёр нь хамтдаа дөрвөн жил амьдарч буй лесбиян хос. С.-ийн төрсөн ах нь эцэг эхээсээ өвлөсөн үл хөдлөх хөрөнгийн С.-д ноогдох хувийг өгөхөөс татгалзаж, “Энгийн болсон цагт чинь байр, машин авч өгнө” гэж тулган шаарддаг.

2014 оны 8, 9-р сард ЛГБТ Төв нь “Тэгш эрх, бахархлын өдрүүд”-ийн хүрээнд ЛГБТ эрхийн талаар мэдлэг мэдээлэл өгөх, үл ялгаварлах, тэгш эрхийг сурталчлах зорилготой бүрэн кино наадам болон уран зураг, зургийн үзэсгэлэн зохион байгуулахын тулд төсвөөс санхүүждэг, төв болон орон нутгийн засгийн газрын шууд харьяалалд байдаг соёл урлагийн олон байгууллагад хандсан ч эдгээр орон зайг ашиглуулахгүй гэсэн хариу авсан. Энэ нь ЛГБТ хүмүүсийн эсрэг төр шууд болон шууд бус ялгаварлан гадуурхалт үйлдэж буй асуудал мөн ба ЛГБТ хүмүүсийн соёлын орон зайг ашиглах, соёлын амьдралд оролцох эрхийг нь үгүйсгэж буй хэлбэр юм.

МОНГОЛЫН ХҮНИЙ ЭРХИЙН ТББ-УУДЫН ФОРУМААС ДАРААХ ЗӨВЛӨМЖИЙГ САНАЛ БОЛГОЖ БАЙНА:

1. Хүний эрхийн төлөв байдлын эхний хэлэлцүүлгээс ЛГБТ хүмүүсийн эрхэд хамаатай зөвлөмжүүдийг бүрэн хэрэгжүүлэх. Үүнд: Засгийн газраас бэлгийн цөөнх хүмүүсийг нэн даруй, үр дүнтэй хамгаалах эрх зүйн тогтолцоог бүрдүүлэх зорилгоор ялгаварлан гадуурхалтын эсрэг хууль батлах, ЛГБТ хүмүүсийн тэгш эрхийг хангах, хөхиүлэн дэмжих орчинг бүрдүүлэхийн тулд хүний эрхийн боловсролд дэд бүтэц, техник, санхүүгийн дэмжлэг үзүүлэх, үзэн ядалтаас үүдэлтэй гэмт хэргийн эсрэг хуультай болох, ингэснээр ийм гэмт хэргийн хохирогчдын зөрчигдсэн эрхийг цаг алдалгүй эрүүгийн, захиргааны, иргэний эрх зүйн хүрээнд сэргээх нөхцөлийг бүрдүүлэх.
2. ЛГБТ хүмүүсийн дэд олон нийт бүрийн эрүүл мэндийн нөхцөл байдлыг бүрэн тодорхойлох, хэрэгцээнд үндэслэсэн эрүүл мэндийг хамгаалах үйлчилгээ үзүүлэх, ЛГБТ олон нийтийн дэд олон нийт бүрийн тодорхой өөр өөр хэрэгцээг эрүүл мэндийн даатгалд хамруулах, эрүүл мэндийн салбарт бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийллээр үл ялгаварлах ёс зүйн хэм хэмжээг хуульчлах.
3. Монгол Улсын Засгийн газар нь олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэн насанд хүрсэн, харилцан зөвшилцсөн бүх хүнд гэр бүл зохиох эрхийг нь ялгаварлалгүй эдлүүлэхийн тулд ижил хүйсийн хосууд болон тэдний хүүхдүүдийг үр дүнтэй хамгаалах, гэр бүлийг нь хүлээн зөвшөөрөхийг оролцуулан эрх зүйн шинэчлэлийг хийх.